

Сүрьеэ, өвчтөний мэдээлэл (2016-05-03)

Халдвар хамгааллын эмч нарын халдвар хамгааллын хуудас

Та яагаад энэ мэдээллийг авч байгаа вэ?

Та сүрьеэтэй эсвэл тийм байх магадлалтай бол танд эмчилгээ шаардлагатай. Энэ хуудасд сүрьеэ, түүнийг хэрхэн эмчлэх мөн та юу хийх ёстой талаар мэдээлэл бий.

Сүрьеэ гэж юу вэ?

Сүрьеэ (мөн үүнийг ТВ буюу ТВС гэж нэрлэдэг) нь халдварт өвчин бөгөөд *Mycobacterium tuberculosis* гэгч бактерийн халдвар юм. Сүрьеэ нь ихэвчлэн уушгины хатгалгаа үүсгэдэг ч заримдаа тунгалагийн булчирхай, уушигны гялтан хальс, яс, тархи, бөөр гэх мэт биеийн бусад эрхтэнд нөлөөлж болно. Өвчний шинж тэмдэг ихэвчлэн халдвар авснаас урт хугацааны (сар эсвэл жил) дараа илэрдэг. Бага насны хүүхэд болон сул дархлаатай хүмүүст өвчний явц илүү хурдан байж, маш ноцтой байдал үүсч болно.

Яаж сүрьеэний халдвар авдаг вэ?

Өвчин нь уушиг эсвэл амьсгалын замдаа сүрьеэтэй хүнээс халдварлана. Бактери нь өрөө танхимын агаараар дамжина, жишээ нь нэг хүн ханиах үед нөгөө хүн нь бактеритэй жижиг дуслуудыг амьсгалж халдвар авна. Сүрьеэ ихэвчлэн ойрын, удаан хугацаагаар холбоотой хүнд дамжина. Тиймд ихэвчлэн нэг өрхийн хүмүүс халдвар авах эрсдэл өндөр. Эцэг эх хүүхэддээ, тэр ч байтугай дотнын найздаа халдвар тарааж болно. Харин богино түр зуурын хугацаанд, жишээ нь ажил сургууль дээрээ хүнтэй уулзахад халдвар авах нь ховор.

Яаж сүрьеэтэйгээ мэдэх вэ?

Нийтлэг шинж тэмдэг нь жин буурах, удаан хугацаагаар ханиалгах, шөнө хөлрөх, халуурах. Сүрьеэний бактери биеийн хаана суусан байгаагаас хамааран шинж тэмдэг өөр өөр байна. Амьсгалын замд суусан сүрьеэ ихэвчлэн удаан хугацааны ханиалгын шалтгаан болдог. Бусад шинж тэмдэг нь хаван (булчирхайн сүрьеэ) эсвэл өвдөлт (яс эсвэл хэвлийн сүрьеэ) байж болно. Шинж тэмдэг нь хэр удаан өвчтэй байснаас хамаарна, мөн бараг байхгүйгээс маш ноцтой түвшинд, хүнээс хүнд өөр байдаг.

Сүрьеэ хэр их халдвартай вэ?

Уушигны сүрьеэтэй буюу цэрээс нь бактери илрэх хүмүүс эмчилгээ хийлгэхээс өмнө бусдад маш халдвартай байж болно. Эмчилгээ эхлэнгүүт эхний хэдэн долоо хоногийн дотор халдварлах чадавхи огцом буурдаг. Сүрьеэ уушиг болон гуурсан хоолойгоос өөр газар суусан бол халдваргүй. Сүрьеэтэй бага насны хүүхэд бараг хэзээ ч бусдад халдваргүй. Сүрьеэ хувцас эсвэл бусад зүйлээр дамжин халдахгүй, мөн гадаа орчинд халдахгүй.

Сүрьеэ аюултай юу?

Сүрьеэг эмчлэхгүй бол бактери нь тархаж бусад эд эрхтэнг довтлоно. Эмчлээгүй сүрьеэ ноцтой гэмтэл учруулж болно заримдаа бүр амь насанд аюултай. Бага насны хүүхэд болон сул дархлаатай хүмүүс сүрьеэгээр хүнд өвчлөх эрсдэл тун өндөр. Амьсгалын замын сүрьеэтэй хүн бусдад халдвартай.

Сүрьеэг хэрхэн эмчлэх вэ?

Өвчин үүсгэдэг бактерийг устгах шахмал эм ууснаар сүрьеэг эмчлэнэ. Эмчилгээ удаан хугацаагаар, олон сарын турш үргэлжилнэ. Эмчийн өгсөн эмчилгээг дагах нь маш чухал. Зарим эмийг ходоод хоосон (ихэвчлэн өглөөний цайнаас нэг цагийн өмнө) үед хэрэглэх ёстой. Мөн шахмал эмийн алийг нь ч мартажгүй байх нь чухал. Эмчлэгч эмчийн зааврыг дага. Эмчилгээнд хайхрамжгүй хандвал бактери тэсвэртэй, эмчлэхэд хэцүү болох магадлалтай юм. Сүрьеэний эм авах, түүнчлэн эмчтэй уулзахад үнэгүй.

Халдварын мөрдөлт - энэ юу гэсэн үг вэ?

Сүрьеэтэй хүмүүсийг олж, тэднийг эмчлэх нь маш чухал, ингэснээр нэгд, тэд гэмтэл (дээр дурдсан) авах, хоёрт, халдвар улам олон хүнд тарах эрсдэл багасгах юм. Тиймд та сүрьеэтэй бол ойр амьдарсан эсвэл уулзсан хүн, мөн таны халдвар өгсөн байж болох эсвэл танд халдвар өгсөн байж болох хүмүүсийг хэн бэ гэдгийг хэлэх ёстой. Халдвар авсан хүн заавал өвчний шинж тэмдэгтэй байх албагүй.

Сүрьеэ Халдвар хамгааллын хуульд орсон байдаг - энэ юу гэсэн үг вэ?

Та сүрьеэтэй бол бусдад халдвар өгөх эрсдэл авахгүй тийм маягаар амьдрах ёстой.

Сүрьеэтэй эсвэл тийм байх магадлалтай хүн эмчлэгч эмчийн өгсөн дараах дүрэм журмыг мөрдөх ёстой:

- Та бусдад халдвартай сүрьеэтэй бол
 - эмнэлэгт хэвтэж эмчлүүлэх ёстой болж магадгүй;
 - та эмчилгээ хийлгүүлж бусдад халдваргүй болж, эмчлэгч эмч таныг бусдад халдваргүй гэж хэлтэл ажил, сургууль болон чөлөөт цагийн үйл ажиллагаа явуулж болохгүй.
- Эмч танд эргэж ирэх цаг өгсөн бол заавал очих ёстой.
- Та нүүвэл эмчлэгч эмчид энэ тухай мэдэгдэх ёстой.

Та өөрт өгсөн мөрдөх дүрэм журмыг буруу гэж үзэж байвал харьяаллын эмнэлгийн халдвар хамгааллын эмчтэй холбоо барьж болно.

Та нэмэлт мэдээлэл авахыг хүсч байна уу?

Сүрьеэний талаарх нэмэлт мэдээллийг дараах хуудсаас уншиж болно:

www.1177.se

www.folkhalsomyndigheten.se